318

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

Эрсдэлийн удирдлагын хэлтсийн гаалийн улсын байцаагч
Ванчиндорж овогтой Болормаагийн
2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дуус-сан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”** | | | | | | | |
| 1. | Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хүрээнд өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна. | Хэрэг-жилт, гүйцэт-гэлээр | - | | Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч Гаалийн хууль тогтоомжийг дагаж мөрдсөн байдлыг 2022-2023 оны байдлаар ХБГ-аас 2023 оны 329 дүгээр дотоод зурвасаар ирүүлсэн ГИТ-ийн жагсаалт; КАЙС-ийн Зөрчлийн мэдээллийн сан; https://opendatalab.mn/; https://www.zangia.mn/job/list зэрэг судалгааны эх сурвалжийг ашиглаж судалсан. Судалгаанд үндэслэж, 7 санал боловсруулж, ХБГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>Дорнод аймаг дахь гаалийн газрын 01/154 дүгээр албан бичгээр ирүүлсэн эрсдэлийн төрөлжсөн судалгаа (2022-2023 онд гаалийн хилээр бараа нэвтрүүлсэн иргэн, ААН-ийн гаалийн бүрдүүлэлтэд хийсэн эрсдэлийн төрөлжсөн судалгаа)-тай танилцаж, эрсдэлийн удирдлага хариуцсан ГУБ-д эрсдэлийн төрөлжсөн судалгаа хийхдээ “БДШ-ын үр дүн”,” Шалгалтын үр дүн”, зөрчлийн мэдээлэл, “Барааны ангиллын код”, “Шалгуурын нэр, дугаар” үзүүлэлтийг оруулах, шалгуурын хүсэлт ирүүлэх талаар чиглэл өгсөн.<br><br>Тус газрын 2024.06.06-ны өдрийн 01/253 дугаар албан бичгээр | 01.01-12.10 | 88.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ирүүлсэн “Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт”-ийг үндэслэж "Шинь Шинь" ХХК-ийн гаалийн бүрдүүлэлтэд эрсдэлийн товч судалгаа хийсэн. Судалгааны үр дүнд тус компанийн экспортын бараанд хамаарах зөвшөөрөгдсөн шалгуур-1, импортын бараанд хамаарах үл хамаарах шалгуур-1, системийн хэмжээнд зүйлийн түвшинд импортын барааны өндөр эрсдэлийн шалгуур-1 (эрсдэлийн түүх-3, хяналтын хуудас-3)-ийг тус тус боловсруулж, удирдлагаар хянуулж батлуулсан.<br>Ноос, ноолуурын экспортын гаалийн бүрдүүлэлтийн явцад гардаг хүндрэлийг арилгахаар Ханбогд Кашимер ХХК-ийн 2024.01.01-2024.11.30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийгдсэн экспортын барааны гаалийн бүрдүүлэлтийн судалгаа хийж, санал дүгнэлт боловсруулсан. | | |
| 2. | Гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна. | Хэрэг-жилт, гүйцэт-гэлээр | - | 2.1.Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна.<br>2.2.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн | **2.1.Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажилласан байна.**<br>**1.**БНСУ, БНХАУ-ын гаалийн байгууллагатай ГИААН-ийн “Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр” (цаашид ХХЗХ)-ийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээлэл солилцох дараах 5 чиглэлийг 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар дотоод зурвасаар Гадаад хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлсэн. Үүнд:<br>-Аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгосны дараах Гаалийн байгууллага, ГИААН-ийн хамтын ажиллагаа;<br>-АЕО таних тэмдгийн талаарх мэдээлэл;<br>-Талуудын ГИААН-ийн мэдээллийг солилцох хэлбэр болон гаалийн хяналт, бүрдүүлэлтийн системд таних арга;<br>-ГИААН-ийн асуудлыг хариуцсан талуудын холбоо баригч нарыг томилох;<br>-БНСУ, БНХАУ-ын гаалийн байгууллагаас Монгол Улсын гаалийн байгууллагын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид үзүүлэх хөнгөлөлт.<br><br>**2.**ГХАХ-тэй хамтарч ажилласны үр дүнд БНСУ-ын Гаалийн байгууллагатай хамтарч дараах цахим уулзалт зохион байгуулагдсан.Үүнд:<br>-2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр БНСУ-ын Гаалийн байгууллагын ГИААН хөтөлбөр хариуцсан нэгжийн албан хаагчидтай цахимаар зохион байгуулсан уулзалт. Цахим | 01.01-12.10 | 95.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна. | уулзалтаар хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх, Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн мэдээллийг харилцан солилцох, эхний ээлжинд БНСУ-ын гаалийн байгууллагаас 3 ГИААН-ийн мэдээллийг Монгол Улсын гаалийн байгууллагад илгээх, Хэлэлцээрийг туршилтаар хэрэгжүүлж, үр дүнд үндэслэж 2 талаас албан ёсоор хэрэгжүүлэх хугацааг товлохоор тохиролцсон.<br><br>Тайлант хугацаанд БНСУ-ын гаалийн байгууллага 3 ГИААН, Монголын гаалийн байгууллагаас "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээллийг харилцан солилцсон.<br><br>-Мөн тус гаалийн байгууллагатай цахим шуудангаар харилцан мэдээлэл солилцож ажилласны үр дүнд ХХЗХ-ийг хэрэгжүүлэх талаар цахим уулзалтыг 2024.02.23-ны өдөр зохион байгуулсан.<br><br>-БНХАУ-ын Гаалийн байгууллагатай цахимаар мэдээлэл солилцож хамтарч ажилласан. ГИААН хөтөлбөрийн талаар цахим шуудангаар мэдээлэл хүлээн авсан. Хятадын гаалийн байгууллагаас 3, Монголын гаалийн байгууллагаас 1 ГИААН-ийн мэдээллийг харилцан солилцсон.<br><br>-Мөн тус гаалийн байгууллагатай цахим шуудангаар харилцан мэдээлэл солилцож ажилласны үр дүнд ХХЗХ-ийг хэрэгжүүлэх талаар цахим уулзалтыг 2024.11.19-ний өдөр зохион байгуулсан.<br><br>**3**.ОХУ-ын ХГА-ны Гаалийн хяналт бүрдүүлэлтийг зохион байгуулах төв газар, Гадаад хамтын ажиллагааны нэгжтэй хамтарч 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр цахим уулзалт зохион байгуулсан. Уулзалтад оролцох албан хаагчдыг мэдээллээр хангаж, илтгэл бэлтгэж уулзалтын бэлтгэл ажлыг хангаж ажилласан.<br><br>-Энэхүү уулзалтаар 2 талын ГИААН хөтөлбөрийн талаар болон харилцан томилолтоор ажиллах талаар мэдээлэл солилцсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **4.**Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын гаалийн байгуулага хамтран Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар Улаанбаатар хотноо 2024 оны 4 сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.<br><br>-Уг семинарт бусад орны гаалийн байгууллагууд, тэдгээрийн дотор БНХАУ, БНСУ-ын гаалийн байгууллагын албан хаагчид цахимаар болон биечлэн оролцож, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар Монгол Улсын ГХЯ, ЭЗХЯ, гаалийн байгууллагын төрийн албан хаагчид болон бизнесийн байгууллагуудын төлөөлөгчдөд мэдээлэл өгч, туршлагаа хуваалцсан.<br><br>-Сургалтад оролцогчийн хувьд ГИААН хөтөлбөрийн ирээдүй, мэдээллийн аюулгүй байдал, Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр, Хөтөлбөрийн схем, блокчэйн болон хиймэл оюун ухааныг ашиглах зэрэг сэдвүүдээр мэргэжилтэн, экспертүүдийн илтгэлийг сонссон.<br><br>-"ГИААН хөтөлбөрийн талаар гадаад худалдаанд оролцогчдын мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ" сэдвээр илтгэл бэлтгэж, сургалтад оролцогчдод танилцуулж, брошюр тараасан.<br><br>**5.**2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулагдсан Их түмэн санаачилгын Гаалийн дэд хорооны болон Худалдаа хөрөнгө оруулалтын 6 дугаар хуралдаанд оролцсон.<br><br>/Энэхүү арга хэмжээнд НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комисс, Их түмэн санаачилгын Нарийн бичгийн даргын газар, БНХАУ-ын Худалдааны яам, БНСУ-ын Санхүү, эдийн засгийн яам, ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яам, Монгол Улсын Эдийн засгийн хөгжлийн яам, МҮХАҮТ болон Их түмэн санаачилгын гишүүн БНСУ, БНХАУ, ОХУ, Монгол Улсын Гаалийн байгууллагын давхардсан тоогоор 75 гаруй төлөөлөгчид оролцсон/ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **6.**Бүгд Найрамдах Солонгос Улсын Гаалийн хүний нөөцийн хөгжлийн институтэд 2024 оны 09 дүгээр сарын 02-10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр”-ийн олон улсын мэргэжилтнүүдэд зориулсан семинарт оролцож, илтгэл тавьж, холбогдох тайланг ГЕГ-ын ЗУГ-т танилцуулсан.<br><br>Тус институтээс ирүүлсэн зааврын дагуу Монголын Гаалийн байгууллагын ГИААН хөтөлбөрийн өнөөгийн байдалд СВОТ шинжилгээ хийж, сургалтын явцад танилцуулсан. 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдөр сургалтын дараа хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулга бэлтгэж, БНСУ-ын ГХНХИ (Гаалийн хүний нөөцийн хөгжлийн институт)-д хүргүүлсэн.<br><br>**<u>Хүрсэн үр дүн:</u>**<br><br>**1.**ХХЗХ-ийг хэрэгжүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр БНСУ , БНХАУ-ын гаалийн байгууллагаас тус бүр 3 ГИААН-ийн мэдээллийг хүлээн авч, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын мэдээллийг цахимаар илгээсэн.<br><br>**2.**Хэлэлцээрийг хэрэгжүүлэх чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, БНСУ-ын Гаалийн байгууллагын төлөөлөгчид Монгол Улсын гаалийн байгууллагад 2025 оны эхний хагас жилд томилолтоор ирж ажиллахаар тохиролцсон.<br><br>**3.**Талууд 2023 онд гарын үсэг зурсан ГИААН хөтөлбөрийн чиглэлээр ХХЗХ байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Монголын төлөөлөгчид ИААН-ийн хөтөлбөрийн хэрэгжилт, баталгаажуулалтын үйл явцыг газар дээр нь ажиглах зорилгоор ОХУ-ын ХГА-д 2024 оны 12 дугаар сард томилолтоор ажиллахаар бэлтгэл ажлаа хангаж байна.<br>**4.**Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинар Улаанбаатар хотноо 2024 оны 4 сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус сургалтад хамрагдаж, мэдлэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | чадвараа дээшлүүлсэн. Сургалтад оролцогчдод "ГИААН хөтөлбөрийн талаар гадаад худалдаанд оролцогчдын мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ"-ний талаар мэдээлэл өгч, танилцуулсан.<br>**5.**ГИААН хөтөлбөрийн өнөөгийн байдалд СВОТ шинжилгээ хийж, БНСУ-ын ГИААН хөтөлбөрийн хэрэгжилтийн туршлагаас суралцсан.<br><br>**2.2.Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна**<br><br>ГИААН хөтөлбөрийг сурталчлан таниулахаар хийсэн ажил:<br><br>**1**.Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC), Монгол Улсын гаалийн байгууллага хамтран зохион байгуулсан ИААН-ийн хөтөлбөрийг сайжруулах, тогтвортой болгох үндэсний семинарт илтгэл бэлтгэж, сургалтад оролцогчдод танилцуулж, брошюр тараасан.<br>**2.**"Менежментийн форум-2024" арга хэмжээнд 2024.03.13-нд оролцож, бизнес эрхлэгчдэд "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж" хөтөлбөрийн брошюр тарааж, Юнивишн, Юнител, Мобиком, Шангрила ХХК-ийн төлөөлөгчдөд хөтөлбөрийн талаар товч танилцуулж, зөвлөгөө өгсөн.<br>**3.**УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br><br>**4.**Гадаад худалдаа эрхлэгчид, "Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр"-т хамрагдахаар хүсэлт гаргасан ААН, ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын албан хаагчдыг арга зүй, зөвлөмжөөр хангах зорилгоор дараах сургалт, уулзалтад оролцож, танилцуулга хийж, холбогдох асуултад хариулсан. Үүнд:<br><br>-УБГГ-ын холбогдох удирдлагууд, ЭУА-ны албан хаагчид (8), | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ААН-ийн төлөөөлөл (4) -тэй хийсэн уулзалт, сургалт. Нийт 12 хүн.<br>-"Говь" ХК-ийн удирдлагын төлөөлөл-9<br>-"Ханбогд кашимер" ХХК-ийн ажилтнууд-5, УБГГ-ын ЭУА-ны 2 ГУБ.<br>-Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын хурлын танхимд, ЭУА-ны 6 ГУБ, ГУАБ, 21 ААН-ийн төлөөлөл<br><br>**5.**Дээр дурдсан ААН-үүдийн менежерүүдэд биет уулзалт, цахимаар болон утсаар удаа дараа холбоо барьж өөрийн үнэлгээний хуудсыг хэрхэн нөхөн бичих талаар зөвөлгөө өгсөн.<br>-Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (АЕО)-т хамрагдах үйлчилгээний холбоос (https://gaali.mn/service/gaaliin-itgemjlegdsen-aj-akhuin-negj-khutulbur(aeo)-t-khamragdakh-khuselt--gargakh)-т хүсэлтийг хүлээн авах хугацаа (2 хоног гэснийг 3), хууль эрх зүй хэсгийн файл, холбоосыг нээгдэх боломжтой болгосон. Мөн "Үйлчилгээний танилцуулга"-ын Нэмэлт мэдээлэл хэсэгт "Гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн жагсаалт"-ыг харах линк/холбоосыг нэмж оруулсан.<br>**6.**Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас (https://customs.gov.mn/)-ын "Гаалийн хяналт, бүрдүүлэлт, зөрчил" хэсэгт ГИААН-ийн хөтөлбөрийн танилцуулга, эрх зүйн хэм хэмжээний акт, ГИААН-ийн жагсаалтыг оруулсан.<br>**<u>Хүрсэн үр дүн:</u>**<br>-Гаалийн харилцаанд оролцогчид ГИААН хөтөлбөрийн талаар мэдээлэл авч, хөтөлбөрт хамрагдах хүсэл эрмэлзлэлтэй болсон;<br>-Иргэн, аж ахуйн нэгжийн цахимаар мэдээлэл авах боломж нэмэгдсэн<br>.<br>**3.ГИААН хөтөлбөрийн хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн бусад ажлууд:**<br><br>**<u>3.1.ААН-д итгэмжлэл олгох ажлын хэрэгжилтэд оролцсон байна.</u>**<br><br>**1.**УБГГ-аас албан бичгээр ирүүлсэн судалгаанд үндэслэж, Говь ХК, АПУ ХК, Сор кашимер ХХК, Ханбогд кашимер ХХК, Янмал ХХК-д "ГИААН хөтөлбөр"-ийн тухай болон хөтөлбөрт хамрагдах боломжийн талаар 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 02-1/1534, 02-1/1535, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 02-1/1536, 02-1/1537, 02-1/1538 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн.<br><br>**2.**Говь ХК 01/726, АПУ ХК 01/666, Ханбогд Кашимер ХХК 2/077 дугаар албан бичгээр ГИААН хөтөлбөрт хамрагдахаар хүсэлт ирүүлсний дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:<br><br>**3.**Арга зүй зөвлөмжөөр хангах зорилгоор 5 удаагийн уулзалт, сургалтын үеэр 52 хүнд мэдээлэл өгч, арга зүй, зөвлөмжөөр хангаж ажилласан.<br><br>**4.**ГЕГ-ын даргын батласан 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн “Гаалийн итгэмжлэл олгох шалгуурыг үнэлэх, баталгаажуулах ажлын удирдамж”-ын дагуу байгуулсан Ажлын хэсэгт ажиллаж, гишүүдийн хамт Ханбогд ХХК-ийн бичиг баримтын болон ажлын байрны баталгаажуулалтыг хийсэн.<br><br>**<u>Хүрсэн үр дүн:</u>**<br>-Тус хэлтсээс 3 ААН-д Гаалийн итгэмжлэл олгох шийдвэр гаргуулахаар Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Ажлын хэсгийн гишүүний хувьд энэхүү арга хэмжээний хэргэжилтэд хувь нэмрээ оруулсан.<br><br>**<u>3.2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтарч ажилласан: Үүнд:</u>**<br><br>-Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан “Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам”-ын 5.9 дэх хэсэгт заасны дагуу ГЕГ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулж, тус ТӨҮГ-т албан бичгээр болон цахимаар удаа дараа хүргүүлж, санал солилцсон.<br>-ГЕГ-ын 2024 оны 01 сарын 18-ны өдрийн 02-1.1/252 дугаар албан бичгээр ГЕГ-ын даргын “Гаалийн итгэмжлэл олгох тухай” 2023 оны 640 дүгээр тушаалын хуулбар, ГЕГ, “Эрдэнэт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлдвэр” ТӨҮГ-ын Хамтран ажиллах гэрээний төслийг хавсаргаж хүргүүлсэн.<br>-ГЕГ-ын Хуулийн хэлтсээр хянуулж, эцэслэн боловсруулсан төслийг удирдлагаар баталгаажуулж, 2024 оны 04 сарын 17-ны өдрийн 02/1487 дугаартай албан бичгээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хүргүүлсэн.<br>- Тус ТӨҮГ-аас баталгаажуулж ирүүлсэн гэрээг Хуулийн хэлтэст бүртгүүлж, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, Орхон гаалийн газарт хүргүүүлсэн.<br><br>-“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны 03 сарын 29-ний өдрийн “Хүндрэлтэй зарим асуудлуудыг хамтран шийдвэрлэх тухай” ГЕ-131-12/1524 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлүүлэх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: Үүнд:<br>-2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр ГЕГ-ын холбогдох нэгжүүдийн уулзалтад оролцсон.<br>-Саналыг судлаад тус хэлтсийн чиг үүрэгтэй холбоотой 12, 13 дугаар хүсэлтэд 5 санал боловсруулж, ХБГ-т 2024 оны 05 дугаар сарын 89 дүгээр ДЗ-аар ХБГ-т хүргүүлсэн.<br>-2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Бүх талууд (ГЕГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Орхон ГГ)-ын уулзалтад оролцсон.<br><br>-Орхон аймаг дахь гаалийн газарт “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллаж, ГИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг дүгнэж, тайлан ирүүлэх талаар 2024.12.10-ны өдрийн 02-1.1/5140 дүгээр албан бичгийг хүргүүлсэн.<br><br>**<u>3.3.ГИААН хөтөлбөртэй холбоотой дараах тайланг үнэн зөв гаргаж, холбогдох нэгж, байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан.</u>** Үүнд:<br>-Захиргааны удирдлагын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 170 дугаар дотоод зурвасын Нэгдүгээр хавсралтад заасан хүснэгтийн дагуу ГИААН-ийн чиглэлээр хэрэгжүүлсэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээний биелэлтийн тайланг бичиж, цахимаар хүргүүлсэн.<br>-2023 онд Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг гаргаж, ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>-2024.01.31-нд Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 25 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээний биелэлтийг гаргаж, ХБГ-т цахимаар хүргүүлсэн.<br><br>-ЗГ-ын “Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай” 2023 оны 178 дугаар тогтоолын дараах заалтуудын хэрэгжилтийн тайланг гаргаж, сар бүр Хуулийн хэлтэст, улирал тутамд Хяналт бүрдүүлэлтийн газарт хүргүүлж ажилласан.<br>3.3.Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан "Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх;<br>3.4."Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуй нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"-д заасан аж ахуйн нэгжид тавигдах шаардлагыг оновчтой болгох, итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах.<br><br>**3.4.ГИААН хөтөлбөртэй холбоотой 9 албан бичиг 7 дотоод зурвасыг боловсруулж, холбогдох нэгж, байгуулагуудад хүргүүлж ажилласан.**<br><br>**3.5.ГИААН хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Аствишн ХХК-ийн мэргэжилтэнүүдтэй хамтарч дараах программуудад өөрчлөлт оруулсан.** Үүнд:<br>• Гаалийн цахим үйлчилгээний системийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (AEO)-т хамрагдах | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээтэй холбоотой программ;<br>· Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын программ.<br>- **Гаалийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл, хяналтын программд:**<br>· Хянах самбарт хүсэлтийн төлвийн нэрийг өөрчилсөн.<br>· "Худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлын стандартыг хангасан аж ахуйн нэгжид гаалийн итгэмжлэл олгох журам"-д нийцүүлж, хүсэлт хүлээн авсан, хүсэлт буцаасан төлвийн нэрийг тус тус оруулсан.<br>· ААН-ээс "Буцаасан хүсэлт"-ийг дахин илгээхэд "шинэ хүсэлт" төлөвтэй хянах самбарт харагдаж, шинэ дугаараар бүртгэгдсэн алдааг залруулсан.<br>· Удирдамж хэсэгт ГЕГ-ын ЗББНДБ, ГГХ-д, тэдгээрт харьяалагдах албан хаагчдыг шалгалтын бүрэлдэхүүнд оруулах, дэлгэцэнд харагдах, удирдамжийг засварт буцаах, шалгалтын бүрэлдэхүүнд ГЕГ-ын ЭУХ-ээс өөр нэгж болон харьяа ГГХ-дын албан хаагчид болон ГУАБ, албаны даргыг сонгох боломжтой болсон.<br>· БДШ-ын программын Аж ахуйн нэгжийн мэдээлэл (ААН-ийн мэдээлэл-11, Гаалийн бүрдүүлэлт, хууль сахилт-6) хэсгийг энэхүү бүртгэл, хяналтын программд татаж, мэдээллийг хяналтад ашиглах, ААН-ийн мэдээллийг Хурын мэдээлэлтэй жиших боломжтой болсон.<br>· ААН-ийн хүсэлтийг хүлээн аваад, бичиг баримтын бүрдлийг шалгах шатанд ААН-ийн хавсаргаж илгээсэн бичиг баримтыг программд харах боломжтой болсон. ААН-ийн Санхүүгийн мэдээлэл харагдахгүй байсан алдааг залруулсан.<br>· Өөрийн үнэлгээг үнэлж, баталгаажуулах явцад, ААН-ээс бичиг баримтыг программд нэмж оруулах хүсэлтийг илгээж, хүлээн авах боломжтой болсон. Өмнө нь цахим шуудангаар авч, ГУБ өөрөө нэмэлт бичиг баримтын жагсаалтад оруулахаар тохируулсан байсан.<br>· ААН-ийн цахимаар ирүүлсэн өөрийн үнэлгээг хүлээн авч, бичиг баримтын болон ажлын байрны баталгажуулалтыг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | программд хийх боломжтой болсон. (өмнө нь бичиг баримтын болон ажлын байрны баталгаажуулалтын үед эксэл файлыг ашиглаж, үнэлгээ хийж, эцэслэн мэдээллийг программд оруулж, баталгаажуулдаг байсан)<br>- **Гаалийн цахим үйлчилгээний системийн Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (AEO)-т хамрагдах үйлчилгээтэй холбоотой хэсэгт:**<br>· Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөр (AEO)-т хамрагдах үйлчилгээ (https://gaali.mn/service/gaaliin-itgemjlegdsen-aj-akhuin-negj-khutulbur(aeo)-t-khamragdakh-khuselt--gargakh) холбоост хүсэлтийг хүлээн авах хугацаа (2 хоног гэснийг 3), хууль эрх зүй хэсгийн файл, холбоосыг нээгдэх боломжтой болгосон. Мөн "Үйлчилгээний танилцуулга"-ын Нэмэлт мэдээлэл хэсэгт "Гаалийн итгэмжлэгдсэн ААН-ийн жагсаалт"-ыг харах линк/холбоосыг нэмж оруулсан.<br>- Гаалийн байгууллагын албан ёсны цахим хуудас (https://customs.gov.mn/)-ын "Гаалийн хяналт, бүрдүүлэлт, зөрчил" хэсэгт ГИААН-ийн хөтөлбөрийн танилцуулга, эрх зүйн хэм хэмжээний акт, ГИААН-ийн жагсаалтыг оруулсан. | | |
| **Зорилт 4. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"** | | | | | | | |
| 3 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх | | | | **3.1.**ЭУ-ийн асуудал хариуцсан албан тушаалын тодорхойлолтыг судалж, мэргэжил, мэргэшилтэй холбоотой санал боловсруулж, ЗУГ-т хүргүүлсэн.<br>**3.2.**Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмын төсөлтэй танилцаж, санал боловсруулж, хэлтсийн хамт олноор журмын төслийг хэлэлцэхэд танилцуулсан.<br><br>**3.3.**КАЙС-ийн Эрсдэлийн удирдлага дэд программын "Эрсдэлийн мессеж" цэсэнд нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулсан төсөлтэй танилцаж, санал боловсруулж, хэлтсийн хамт олноор журмын төслийг хэлэлцэхэд танилцуулсан. | 01.01-12.10 | 95.7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | журмыг шинэчлэн найруулж, төслийг боловсруулахад санал боловсруулна. | | | | | | |
| 4 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна. | Хэрэг-жилт, гүйцэт-гэлээр | | | **4.1.**Эрсдэлийн удирдлагын хэлтсийн чиг үүргийн хэрэгжилтийг хангахтай холбоотой хийсэн эрсдэлийн судалгааны тайланд санал өгч хамтарч ажилласан. | 01.01-12.10 | 94 |
| 5 | ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна. | Хэрэг-жилт, гүйцэ-тгэлээр | | Баталгааны маягтыг хуулийн хугацаанд хүлээлгэн өгч, 100 хувь баталгаажуулсан байна. | 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ХАСХОМ-ыг баталгаажуулж баталгааны маягтыг ЗУГ-т хүргүүлсэн. | 01.01-12.10 | 100 |
| 6 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | | | | **6.1.**Тайлант хугацаанд 11 албан бичиг боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн бол 12 байгууллагаас ирүүлсэн албан бичигт хариу хүргүүлж ажилласан.<br><br>**6.2.**Өөрт хуваарилагдсан ирсэн ДЗ-ын хариуг өгч, ДЗ боловсруулж, холбогдох нэгжүүдэд хүргүүлж ажилласан. Үүнд:<br>-ирсэн 39,<br>-явсан 24<br>-ЭУХ-ийн үндсэн үүрэг болон чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд одоогийн батлагдсан албан тушаалын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай эсэх талаар дараах судалгааг хийсэн: Үүнд: | 01.01-12.10 | 94.2 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Одоо ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагийн тооцоо;<br>-Хэлтсийн үндсэн үүрэг, чиг үүргийн харьцуулалт;<br>-Үндсэн ажлаас гадуур болон цаг хугацааны шинжтэй гүйцэтгэсэн ажил.<br>Судалгаанд үндэслэж, ЗУГ-т тус хэлтсийн албан тушаалын орон тоог нэмэгдүүлэх, мэргэжил, мэргэшилтэй холбоотой 3 саналыг боловсруулж, 2024 оны 01 сарын 16-ны өдрийн 14 дүгээр дотоод зурвасаар хүргүүлсэн.<br><br>-Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Бүгд найрамдах Узбекистан Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын Харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд 5 санал боловсруулж, дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>**6.3.**ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад заасан загварын дагуу боловсруулсан. Хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, программд оруулахад хамтарч ажилласан.<br>**6.4.**2024 оны хагас болон бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг хариуцсан асуудлын хүрээнд хэлтсийн болон төрийн жинхэнэ албан хаагчийн түвшинд цаг хугацаанд нь гаргасан.<br>**6.5.**Хариуцсан ГГХ-дын шалгуур үзүүлэлтийг хагас жил, жилээр дүгнэсэн.<br><br>**6.6.**ГЕГ-ын ЗББНДБ-ын дунд 14 хоногт нэг удаа зохион байгуулагддаг 11 удаагийн мэдээллийн цагт оролцсон. | | |
| 7 | Ажлын цаг ашиглалтыг тухай бүр нүүр таних программд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна. | хувиар | | | 2024.01.01-ний өдрөөс 2024.11.30-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 253 хүн өдөр, 2024 цаг ажиллахаас 227 хүн өдөр ажилласан. Ээлжийн амралт: 26 хүн өдөр. Илүү цаг: 20 хүн өдөр буюу 160 цаг, Ажлын цаг ашиглалт: 100 хувь. | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнасан байна. | Хэрэг-жилт, гүйцэ-тгэлээр | | | **8.1.**Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээ байгуулах хоёрдугаар шатны хэлэлцээнд ЭЗХЯ-ны 2024.05.09-ний өдрийн А/107 дугаар тушаалаар "Үйлчилгээний худалдаа", "Хууль эрх зүйн болон институцын асуудал" ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Үүнд:<br><br>-"Хууль эрх зүйн болон институцын асуудал" (2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ГХЯ-д) "Үйлчилгээний худалдаа" (2024 оны 05 дугаар сарын 08-ны өдөр ГХЯ-д) ажлын дэд хэсгийн хуралд тус тус оролцсон.<br>.Монгол Улс, БНСУ-ын хоорондын ЭЗТХ-ийн "Үйлчилгээний худалдаа"-ны ажлын хэсгийн гишүүний хувьд зохион байгуулагдсан Ажлын хэсгийн хуралд оролцсон.<br>-2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр МҮХАҮТ-ын Хурлын их танхимд зохион байгуулагдсан "Эдийн засгийн түншлэлийн болон Чөлөөт худалдааны хэлэлцээр дэх бизнес эрхлэгчдийн оролцоо" нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон.<br>-"Хууль эрх зүйн болон институцын асуудал"-ын ажлын дэд хэсгийн гишүүдэд "Уялдуулсан системийн тухай товч танилцуулга"-ыг бэлтгэж, цахимаар хүргүүлсэн<br>-"Хууль эрх зүйн болон институцын асуудал" хариуцсан ажлын дэд хэсгийн нарийн бичгийн даргад "Гаалийн нэр томьёотой холбоотой санал боловсруулж, цахим шуудангаар хүргүүлсэн.<br>-Хувь хүний шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 2 санал боловсруулж, хүргүүлсэн.<br>-Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийн 2 дугаар раундын хэлэлцээ (2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр "Хууль эрх зүйн болон институцын асуудал", 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр "Үйлчилгээний худалдаа"), Монгол Улс, БНСУ хоорондын ЭЗТХ-ийн 3 дугаар раундын хэлэлцээ (2024 оны 09 дүгээр сард "Үйлчилгээний худалдаа")-нд ажлын дэд хэсгийн гишүүний хувьд тус тус оролцсон.<br>**8.2.**2024 оны 02 дугаар сарын 15-ны өдөр ХХЕГ-т зохион байгуулагдсан "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл (RIBS)"-ийн хүрээнд "Хилийн зохицуулалттай менежмент" сэдвээр сургалтын жишиг хөтөлбөрийг боловсруулах Сургагч багш нарын ээлжит уулзалтад оролцсон.<br>2023 оны 05 дугаар сард эхэлсэн "Эрсдэлийн удирдлага" | 01.01-12.10 | 97.1 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтын хөтөлбөрийг бүрэн боловсруулж, төслийн зөвлөхт хүлээлгэн өгсөн.<br>2024 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 11 цагт ГЕГ-ын хурлын танхимд зохион байгуулагдсан Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сангийн Яам, Гаалийн ерөнхий газраас "Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл"-ийн хүрээнд "Хилийн зохицуулалттай менежмент" сэдвээр боловсруулсан сургалтын хөтөлбөрийн номны нээлтийн арга хэмжээнд оролцсон.<br>**8.3.**МУГЕГ, ОХУ-ын ХГА хоорондын эрсдэлийн удирдлагын хүрээнд хамтран ажиллах тухай хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудлаар 2024 оны 06 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд 2 талын шинжээчдийн анхдугаар уулзалтыг зохион байгуулахад оролцсон: Үүнд:<br>-Уулзалтын зохион байгуулалт хэлэлцэх асуудалтай холбоотой 4 ДЗ боловсруулж, ГХАХ, ХБГ, ЗТГ-т хүргүүлсэн.<br>-ГЗДАС-д 5 гаалийн газар, хороонд санал ирүүлэх үүрэг өгч, ирсэн саналыг нэгтгэн удирдлагуудыг мэдээллээр хангаж ажилласан.<br>-Уулзалтаар хэлэлцэх төлөвлөгөөний болон тэмдэглэлийн төсөл боловсруулах, хэлэлцэх, эцэслэх ажилд хэлтсийн хамт олонтой хамтарч ажилласан. Уулзалтын үр дүнд 2 тал эрсдэлийг удирдах 9 чиглэлээр хамтран ажиллахаар тохиролцсон.<br><br>**8.4.** 2024 оны 08 дугаар сард Жендэрийн тэгш эрх, олон талт байдлыг судлах албан бус ажлын хэсэгт "Ёс зүй" чиглэлээр ажиллаж, ДГБ-ын баримт бичиг болон үндэсний эрх зүйн зохицуулалтыг судалж, 4 санал боловсруулж, ажлын хэсэгт танилцуулсан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ТАЗ-ийн төрийн албан хаагчдад | Хэрэг-жилт | 4 удаа | 6 удаа хамрагдсан | **Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:** Төрийн албаны зөвлөлийн 11 удаагийн цахим сургалтад хамрагдаж, дараах | 01.01-12.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулсан цахим 7:4:10 цахим сургалтад хамрагдах | гүйцэт-гэлээр | | байна. | мэдээллийг олж авсан.<br><br>1. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг<br>2. "Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах" - МУИС-ийн Профессор А.Энхбаяр, VR AR MR<br>3. "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага" – МУИС-ийн зөвлөх, ЭЗШУ-ны доктор, профессор Л.Оюун<br>4. "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"<br>5. "Төрийн албаны үнэт зүйл (эрхэмж), үе хоорондын ялгаатай байдал" - МУИС-ийн ахлах багш, доктор Г.Мягмар<br>6. "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)" - "Чингис хаан" музейн захирал, ШУА-ийн гишүүн, академич, түүхийн шинжлэх ухааны доктор С.Чулуун<br>7. "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга"<br>8. "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга<br>9. "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа"<br>10. "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"<br>11. "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь" | | |
| 2 | Төрийн албан хаагчдад зориулсан "Монгол бичиг"-ийн цахим сургалтад хамрагдах | Хэрэг-жилт гүйцэт-гэлээр | - | 1 удаа | - Цахимаар 4 цагийн сургалтад хамрагдсан | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:** В.Содормаа / В.Содор 2024 оны 12 сарын 10.

Гаалийн улсын байцаагч
( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ВАНЧИНДОРЖ ОВОГТОЙ БОЛОРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Нэгжийн нэр: ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийл-бэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “ОЛОН УЛСЫН ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хүрээнд өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийж, эрсдэлийн удирдлагын программд оруулна. | 54 | 8 | 62 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Гадаад худалдааг хөнгөвчлөх ажлын хүрээнд гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг "Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр" байгуулсан БНХАУ, БНСУ болон бусад олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулсан арга хэмжээг зохион байгуулна. | 58 | 9 | 67 | |
| **Зорилт 4. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.3. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журмыг шинэчлэн найруулж, төслийг | 58 | 9 | 67 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | боловсруулахад санал боловсруулна. | | | | |
| 2. | Арга хэмжээ 1.4. Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд оролцох ажлын хүрээнд нэгжийн эрсдэлийг таньж тогтоож, сан үүсгэхэд хэлтсийн албан хаагчидтай хамтарч ажилласан байна. | 57 | 9 | 66 | |
| 3 | Арга хэмжээ 1.5. ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргаж, 100 хувь баталгаажуулсан байна. | 60 | 10 | 70 | |
| 4 | Арга хэмжээ 1.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна. | 57 | 9 | 66 | |
| 5 | Арга хэмжээ 1.7. Ажлын цаг ашиглалт тасалдалгүй байна. | 60 | 10 | 70 | |
| 6 | Арга хэмжээ 1.8<br>Шаардлагатай тохиолдолд үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийг хэрэгжүүлж, тайлагнасан байна | 59 | 9 | 68 | |
| **Дундаж оноо:** | | | | **67.0** | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 2.1. ТАЗ-ийн төрийн албан хаагчдад зориулсан цахим 7:4:10 цахим сургалтад хамрагдах | 90 | 13.5 | |
| 2 | Арга хэмжээ 2.2. Төрийн албан хаагчдад зориулсан “Монгол бичиг”-ийн цахим сургалтад хамрагдах | 90 | 13.5 | |
| **Дундаж оноо:** | | | **13.5** | |

## 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/Д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 6 | |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Хариуцлагатай байдал | 6 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 6 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1.<br>Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах ур чадвар | 6 | |
| 7 | Мэргэжлийн ур чадвар 2.<br>Бүтээлч байдал | 6 | |
| 8 | Мэргэжлийн ур чадвар 3.<br>Судалгаа, дүн шинжилгээ, дүгнэлт хийх ур чадвар | 6 | |
| **Дундаж оноо:** | | **6** | |

**4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ** (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/Д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| **Дундаж оноо: 7** | | |

**5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

| Д/Д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно) | 67 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 13.7 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.0 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7.0 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =93.7**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | |

213

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .......................... (Д.Цэндсүрэн)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .......................... (В.Болормаа)

2024.12.10 (огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч .......................... (Г.Энхтайван)

12/20, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Хүний нөөцийн хэлтсийн
Гаалийн улсын ахлах байцаагч .......................... (Ө.Тэгшээ)

2024.12.20 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***
Гаалийн ерөнхий газрын дарга .......................... (Р.Отгонжаргал)